



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/423

Улаанбаатар хот

Тамхи худалдах үйл ажиллагаа
эрхлэх зөвшөөрөл сунгах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 11.6, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох эсэх талаар санал, дүгнэлт боловсруулах чиг үүрэг бүхий “Худалдаа, үйлчилгээг зохицуулах зөвлөл”-ийн 2025 оны 09 дүгээр хуралдааны тэмдэглэлийг үндэслэн дүүргийн нутаг дэвсгэрт тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл сунгах 1 аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгогдсон аж ахуйн нэгж байгууллагын тамхи худалдах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс (Б.Номин), Чингэлтэй дүүргийн Цагдаагийн газар (Ц.Түвшинжаргал), хорооны Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг даргын орлогч (Н.Бямбагэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ